

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр сарын 4-
ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 191

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн хороо татан буугдсантай холбогдуулан түүний үндсэн хөрөнгөд бүртгэлтэй энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Сангийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй төрийн байгууллага хооронд балансаас балансад шилжүүлэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Баян-Өлгий, Увс, Ховд аймаг дахь Худалдааны битүү захын барилгуудад иргэдээс оруулсан хөрөнгө оруулалтыг тооцон баталгаажуулсны үндсэн дээр тэдгээрийг дуудлагын худалдаагаар худалдаж, олсон орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болорт даалгасугай.

4. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Болорт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Сангийн сайд

Б.БОЛОР

Засгийн газрын 2016 оны 191 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО (ХУУЧИН НЭРЭЭР)-НЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
САНГИЙН ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

(төгрөгөөр)

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1.	Гатварын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын конторын барилга	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж	315,650,000.0	26,304,166.8	289,345,833.2
2.	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын барилга	Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, Махатма Гандигийн гудамж	5,275,200,000.0	337,026,666.8	4,938,173,333.2
3.	Худалдааны битүү захын барилга	Увс аймгийн Улаангом сум	3,052,500,000.0		
4.	Худалдааны битүү захын барилга	Баян-Өлгий аймгийн Өлгий сум	3,052,500,000.0		
5.	Худалдааны битүү захын барилга	Ховд аймгийн Жаргалант сум	3,663,000,000.0		
6.	Гадна спортын цогцолбор	Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн (шинэ)	1,429,222,309.0		
7.	2,655 км урт дугуй, цана, гүйлтийн хосолсон зам, дугуйн зогсоол	Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн (шинэ)	3,579,922,074.0		
	Дүн		20,367,994,383.00	363,330,833.60	5,227,519,166.40

Засгийн газрын 2016 оны 191 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

(төгрөгөөр)

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Одоо эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлж авах байгууллагын нэр
1.	Увс аймаг дахь хуучин нисэх онгоцны буудлын барилга байгууламж	Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар баг	816,157,954.5	498,190,082.8	317,967,871.7	Иргэний нисэхийн ерөнхий газар	“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар
2.	Зам, тээврийн яамны өргөтгөлийн 2 давхар барилга	Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, Тээвэрчдийн гудамж, Засгийн газрын XIII байрны өргөтгөл	1,006,706,500.0	561,560,778.0	445,145,722.0	Зам, тээврийн яам	“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар
3.	Завхан аймаг дахь Төрийн банкны барилга	Завхан аймгийн Улиастай сумын Жинст багийн Зээлийн гудамж	96,360,000.0	18,468,433.2	77,891,566.8	Төрийн банк	Завхан аймаг дахь 5 дугаар тойргийн Тахарын алба
	Дүн		1,919,224,454.5	1,078,219,293.9	841,005,160.5		

